




# 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



### КОМПАНИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

2020 онд бодлого зохицуулалтын 5 хэлтэс, мэдээлэл технологи, шуурхай удирдлага, засвар туршилт, хэмжүүр тоолуур, автотээврийн 5 алба, ашиглалт борлуулалтын ажлыг эрхлэн гүйцэтгэх 4 салбар, 2 төвтэйгөөр 442 орон тоонд нийт 424 ажилтан байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээтэй, ажиллалаа.

### ДСЦТС ХК-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ







## Худалдан авсан цахилгаан эрчим хүч

2020 оны жилийн эцэст Нэг худалдан авагчаас тодотгосон захиалгаар 477,3 сая кВт\*цаг цахилгаан эрчим хүч худалдан авахаас 484,5 сая кВт\*цаг цахилгаан эрчим хүч худалдан авч төлөвлөгөөнөөс 1,5%-р буюу 7,2 сая.кВт.цагаар өссөн. Харин өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 1,6%-р буюу 7,8 сая.кВт.цагаар өссөн байна.

ЦЭХ-ний хэрэглээ /сая.кВт.цаг/




Худалдаж авсан ЦЭХ /сая.кВт.цаг/





## Борлуулсан цахилгаан эрчим хүч


Тайлант хугацаанд гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөөгөөр 419,5 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч борлуулахаас 440,4 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч борлуулж төлөвлөгөөний биелэлт 102,9% болсон





## Борлуулсан цахилгаан эрчим хүч

Компанийн дүнгээр өнгөрсөн оны мөн үеэс 11,8 сая кВт.ц буюу 2,7%-р өссөн. Шинийн борлуулалт 251,6 сая кВт.ц болж 5,6 сая.кВт.ц буюу 2,2%-р, салбарын борлуулалт 188,8 сая кВт.ц болж 6,2 сая кВт.ц буюу 3,3%-р тус тус өссөн байна.





## Цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал

Тайлант хугацаанд цахилгаан эрчим хүчний нийт алдагдал 9,09% буюу 44.0 сая кВт.цаг болсон нь тодотгосон төлөвлөгөөт алдагдлаас /11.50%/ 2,4 нэгжээр буюу 10.4 сая кВт.цагаар буурсан.


Өмнөх оны гүйцэтгэлээс 1.02 нэгжээр буюу 4.1 сая кВт.цагаар буурсан байна.





## Цахилгаан эрчим хүчний орлого


Гүйцэтгэлд ноогдох орлогын төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд 75.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 79.0 тэрбум төгрөгийн орлого цуглуулж гүйцэтгэлд ноогдох орлогын төлөвлөгөө 103.7% гүйцэтгэлтэй байна.





## Эрчим хүч хэмнэлт

2020 оны Эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө нь 3 бүлэгт багтсан 29 ажил 1215,5 сая төгрөгний зардлаар хийгдэхээр төлөвлөгдөж гүйцэтгэлээр 2 ажил бизнес төлөвлөгөөний тодотголоор хасагдаж бусад ажлууд бүрэн хийгдэж төлөвлөгөөний биелэлт 100 хувь, төлөвлөсөн зардалын гүйцэтгэл 687,8 сая төгрөг болсон.





## ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 2-р сарын 19-ний өдөр

Дугаар 02/01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хувиарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 76 дугаар зүйлийн 76.1.12, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” хувьцаат компани (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2021 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг үндэслэн Компанийн нэгж энгийн хувьцаанд 155 төгрөг 89 мөнгөний ногдол ашиг хувиарласугай.

Хоёр. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021.04.15, ногдол ашиг төлөх өдрийг 2021.10.11-ний өдөр байхаар тогтоосугай.

Гурав. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (С.Нэргүй), Санхүү, Эдийн засгийн хэлтсийн дарга (М.Гэрэлмаа) нарт үүрэг болгосугай.



Ц.БАЯРБААТАР



**“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

**Хурал хуралдах газар, цаг, өдөр:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо Хасвуу Плаза-гийн хурлын танхимд 2021 оны 03-р сарын 21-ны өдөр 11:00-13:00

**Хуралд оролцох гишүүд:** Ц.Баярбаатар, Г.Бэхбат, Л.Балган, Н.Эрдэнэбат, Э.Долгорсүрэн, Б.Эрдэнэбилэг, Т.Энхмэнд, С.Нэргүй, Ц.Хангай.

Хэлэлцэх асуудал	
1.	2020 оны компанийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн дүгнэлт гаргах /Тайлагнагч – Дэд захирал бөгөөд Ерөнхий инженер Б.Батжаргал/
2.	2020 оны аудитлагдсан компанийн санхүүгийн тайланг хэлэлцэн дүгнэлт гаргах /Тайлагнагч –Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан М.Гэрэлмаа/
3.	Эрчим хүчний зохицуулах хороонд танилцуулсан Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах /Тайлагнагч - Эдийн засагч Л.Эрдэнэсугар/
4.	Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хуралдуулахтай холбоотой бусад асуудал /Тайлагнагч - ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Баярманла/

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

---

2021 оны 03-р сарын 21-ний өдөр

Дугаар 03/01

Улаанбаатар хот

Тайлан, төлөвлөгөөг дүгнэн батлах тухай


Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, "Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ" хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2021 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны тайланг хавсралт (Хавсралт 1)-аар баталж хангалттай гэсэн үнэлгээгээр дүгнэсүгэй.

Хоёр. Компанийн 2020 оны аудитлагдсан санхүүгийн тайланг хавсалтаар (Хавсралт 2)-аар баталж хангалттай гэсэн үнэлгээгээр дүгнэсүгэй.

Гурав. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, аудитлагдсан санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хавсралт (Хавсралт 3)-аар баталж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсугай.

Дөрөв. Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг хавсралт (Хавсралт 4)-аар баталсугай

**ДАРГА**  **Ц.БАЯРБААТАР**

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ  
ТУЗ  
ТТА 1929-Н 2698595  
ДАРХАН-УУЛ АЙМАГ

## ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 03-р сарын 21-ний өдөр

Дугаар 03/02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2021 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цагт "Хасвуу" плазагийн хурлын танхимд хуралдуулсугай.

Хоёр. Хурлаар дараах асуудлыг хэлэлцсүгэй: (i) Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах; (ii) Компанийн 2020 оны үйл ажиллагааны үр дүнгээс ногдол ашиг хувиарлах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах; (iii) Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох; (iv) Компанийн ТУЗ-ийн 2021-2022 оны ТУЗ-ийн цалин урамшуулал болон зардлыг батлах.

Гурав. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөр тогтоосугай.

Дөрөв. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөр тогтоон, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журамд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

Тав. Хувьцаа эзэмшигчид нь Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, 2020 оны үйл ажиллагааны тайлан, Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөө, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл болон холбогдох бусад мэдээлэлтэй танилцаж болно.

Зургаа. Хурлын даргаар Ц. Баярбаатарыг томилсугай. Тооллогын комиссын даргаар М.Баярманла, гишүүнээр Б.Ундрал нарыг тус тус томилсугай.

ДАРГА



Ц.БАЯРБААТАР



**"ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

**Хаяг:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо "Хасвуу Плаза"-гийн хурлын танхимд болно.

**Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:** 2021 оны 04-р сарын 30-ны өдөр

**Хурлаар хэлэлцэх асуудал:** Хурлаар дараах асуудлыг хэлэлцсүгэй: (i) Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах; (ii) Компанийн 2020 оны үйл ажиллагааны үр дүнгээс ногдол ашиг хувиарлах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах; (iii) Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох; (iv) Компанийн ТУЗ-ийн 2021-2022 оны ТУЗ-ийн цалин урамшуулал болон зардлыг батлах.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2020 оны 3 дүгээр сарын 31-ны өдрөөс эхлэн ажлын цагаар өөрийн үйлчилгээ авч буй үнэт цаасны компаниуд болон "Хасвуу Плаза"-гийн хурлын танхимд ирж танилцах боломжтой.

Холбоо барих:  
Хурал зохион байгуулах комисс  
Утас: 11-318998

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**  
**НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ШИЙДВЭР**

2021 оны 03-р сарын 21-ний өдөр

Дугаар 03/01

Улаанбаатар хот

ТУЗ -ийн гишүүдэд нэр дэвшүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.22, 7.23, 7.26-д заасныг үндэслэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хороо дараах шийдвэрийг баталсугай.

1. Хараат бус гишүүнд нэр дэвших зөвшөөрлөө бичгээр өгсөн дараах нэр дэвшигчдийг Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсугай. Үүнд:

- (i) Ц.Баярбаатар
- (ii) Л.Балган
- (iii) Г.Бэхбат

2. Дараах гишүүдийг ердийн гишүүдээр нэр дэвшүүлэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсугай. Үүнд:

- (i) Н.Эрдэнэбат
- (ii) Ц.Долгорсүрэн
- (iii) С.Нэргүй
- (iv) Б.Эрдэнэбилэг
- (v) Т.Энхмэнд
- (vi) Ц.Хангай

	<b>Ц.БАЯРБААТАР</b>
ДАРГА	<b>Г.БЭХБАТ</b>
ГИШҮҮН:	<b>Н.ЭРДЭНЭБАТ</b>



**“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД ТАВИГДАХ  
ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ МЭДЭГДЭЛ**

Дор гарын үсэг зурагч миний бие тус компанийн хараат бус гишүүнээр 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс томилогдон ажиллахаар нэр дэвшиж байгаа бөгөөд Монгол Улсын Компанийн тухай хуулийн дараах шаардлагыг хангаж байгаагаа баталж байна. Үүнд:

**79 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**

79.1.Энэ хуулийн 81.2-т заасан нэр дэвшүүлэх хороо нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүний нэрийг дэвшүүлнэ:

79.1.1.өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;

79.1.2.өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;

79.1.3.төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;

79.1.4.компанитай бизнесийн аливаа холбоогүй.

79.1.5.хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад шаардлага.

Гарын үсэг: \_\_\_\_\_ *Д.Талман*

Нэр:

Рд: ХН57040172

Огноо: 2021.03.15

Холбогдох утасны дугаар:



**“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД ТАВИГДАХ  
ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ МЭДЭГДЭЛ**

Дор гарын үсэг зурагч миний бие тус компанийн хараат бус гишүүнээр 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс томилогдон ажиллахаар нэр дэвшиж байгаа бөгөөд Монгол Улсын Компанийн тухай хуулийн дараах шаардлагыг хангаж байгаагаа баталж байна. Үүнд:

**79 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**

79.1. Энэ хуулийн 81.2-т заасан нэр дэвшүүлэх хороо нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүний нэрийг дэвшүүлнэ:

79.1.1. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;

79.1.2. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;

79.1.3. төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;

79.1.4. компанитай бизнесийн аливаа холбоогүй.

79.1.5. хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад шаардлага.

Гарын үсэг: \_\_\_\_\_

Нэр: \_\_\_\_\_

Рд: \_\_\_\_\_

Огноо: 2021.03.15

Холбогдох утасны дугаар: \_\_\_\_\_

99191528





“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”  
ХУВЬЦААТ КОМПАНИ

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД ТАВИГДАХ  
ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ МЭДЭГДЭЛ**

Дор гарын үсэг зурагч миний бие тус компанийн хараат бус гишүүнээр 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс томилогдон ажиллахаар нэр дэвшиж байгаа бөгөөд Монгол Улсын Компанийн тухай хуулийн дараах шаардлагыг хангаж байгаагаа баталж байна. Үүнд:

**79 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**

79.1.Энэ хуулийн 81.2-т заасан нэр дэвшүүлэх хороо нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүний нэрийг дэвшүүлнэ:

79.1.1.өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;

79.1.2.өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;

79.1.3.төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;

79.1.4.компанитай бизнесийн аливаа холбоогүй.

79.1.5.хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад шаардлага.

Гарын үсэг: \_\_\_\_\_

Нэр: БАЯР БААТАР

Рд: 41.55052077

Огноо: 2021.03.15

Холбогдох утасны дугаар: 91927359



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК-ийн хувьцаа эзэмшигч танаа

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

“Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартуудын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

### Санхүүгийн тайлангийн талаархи компанийн удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогыг сонгож, хэрэглэх, тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компаний тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүрэг хариуцлагыг хүлээсэн байна.

### Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компанийн санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Мөн нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлсон.

### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 4-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ" ХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ай Жэй Эй Эйч Аудит ХХК  
Монгол улс, Улаанбаатар хот

Огноо: 2021. 03.18





## ОРЛОГЫН ТАЙЛАН


2020 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

2020 оны 12-р сарын 31

Борлуулалтын орлого	97,795,127,424.56
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	74,819,558,188.46
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>22,975,569,236.10</b>
Түрээсийн орлого	31,697,353.49
Хүүний орлого	1,776,648.01
Бусад орлого	2,528,770,687.71
Борлуулалт маркетингийн зардал	9,841,276,689.16
Ерөнхий ба удирдлагын зардал	11,569,354,024.60
Санхүүгийн зардал	57,262,294.82
Бусад зардал	1,862,153,658.72
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	420,540.42
Үндсэн хөрөнгө данснаас хассаны (гарз)	-
Бусад ашиг /алдагдал/	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>2,208,187,798.43</b>
Орлогын татварын зардал	94,860,249.53
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>2,113,327,548.90</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>2,113,327,548.90</b>

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно



**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**  
 2020 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлан

	/Төгрөгөөр/			
	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагд- сан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31</b>	<b>1,038,511,576.99</b>	<b>63,103,330,971.93</b>	<b>806,223,524.11</b>	<b>64,948,066,073.03</b>
Гаргасан хувьцаат капитал	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал			2,113,327,548.90	2,113,327,548.90
Бусад дэлгэрэнгүй орлого				
<b>2020 оны 12-р сарын 31</b>	<b>1,038,511,576.99</b>	<b>63,103,330,971.93</b>	<b>2,919,551,041.11</b>	<b>67,061,393,590.03</b>



Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
**2020 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлан**

	/Төгрөгөөр/ 2020 оны 12-р сарын 31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>83,596,427,844.18</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	80,663,959,388.31
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	
Бусад мөнгөн орлого	2,932,468,455.87
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>82,523,959,144.42</b>
Ажилчдад төлсөн	8,510,713,580.49
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,298,067,334.28
Бараа материал худалдан авахад төлсөн	8,428,267,153.66
Ашиглалтын зардалд төлсөн	15,742,078.66
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	708,305,824.00
Хүүний төлбөрт төлсөн	633,526.00
Татварын байгууллагад төлсөн	2,770,055,793.84
Даатгалын төлбөрт төлсөн	19,776,720.00
Бусад мөнгөн зарлага	60,772,397,133.49
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,072,468,699.76</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,776,648.01</b>
Хүлээн авсан хүүний орлого	1,776,648.01
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>965,858,894.65</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	798,985,913.19
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	166,872,981.46
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(964,082,246.64)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>(13,578,288.37)</b>
Төрөл бүрийн хандив	(14,060,000.00)
Валютийн зөрүүний орлого	481,711.63
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>(2,171,550.00)</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(2,171,550.00)
Төлсөн ногдол ашиг	
Валютийн зөрүүний алдагдал	(61,171.21)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(15,811,009.58)</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>92,575,443.54</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	390,315,270.62
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	482,890,714.16

*Нэмэлт тодруулууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

